

## **2018 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/427 тушаалын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл бүртгэгдсэн 9 байгууллага /УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, ГССҮТ, УАУХТ, СЭМҮТ, НЭМГ/ мэдээ ирүүлсэн.

### **Нэг. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн амбулаторийн үзлэгийн хүлээгдэл:**

2018 оны 1 дүгээр сард хүлээгдлийн мэдээ ирүүлсэн байгууллагуудаас УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ-ийн амбулаторийн үзлэг хүлээгдэлтэй ажилласан бол ЭХЭМҮТ, ГССҮТ-ийн амбулаторийн кабинетүүдэд хүлээгдэл бүртгэгдээгүй, тусламж үйлчилгээг өдөрт нь үзүүлсэн байна.


УНТЭ-ийн амбулаторийн 5 кабинетэд нийт 39 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнээс: Зүрх судасны кабинетэд 3 хүртэл хоног 25, нүд судлал 8, чих хамар хоолой 3, шүдний эмчилгээ 2, мэдрэл судлалын кабинетэд 1 үйлчлүүлэгч тус бүр 1 хоногийн хугацаатай хүлээгдэлд бүртгэгджээ.

УХТЭ-ийн амбулаторийн 10 кабинетэд нийт 123 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнд: бөөр судлалын кабинетэд 7, зүрх судасны кабинетэд 9 үйлчлүүлэгч, мэдрэл судлал 22, нүдний кабинет 6, хоол боловсруулах эрхтэн судлал 48 үйлчлүүлэгч тус бүр 1-3 хоног, эмэгтэйчүүдийн кабинетэд 10 үйлчлүүлэгч, булчирхай судлал 4, уушгины кабинетэд 6 үйлчлүүлэгч тус бүр 2 хоног, мэс засал 3, чих хамар хоолой 7, урологийн кабинетэд 1 үйлчлүүлэгч тус бүр 1 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.

УГТЭ-ийн зүрх судасны кабинетэд 1-2 хоногийн хугацаанд 34 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна.

ХСҮТ-ийн амбулаторийн 8 кабинетэд нийт 597 үйлчлүүлэгчийн хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнээс толгой хүзүүний мэс заслын кабинетэд 44, эмэгтэйчүүдийн мэс заслын кабинетэд 143, элэг цөс нойр булчирхайн кабинет 59 үйлчлүүлэгч тус бүр 1-ээс 7 ба түүнээс дээш хоногийн хугацаанд, туяа эмчилгээний кабинетэд 37 үйлчлүүлэгч 6 хоног, ерөнхий мэс заслын кабинетэд 45 үйлчлүүлэгч 4 хоног, цээжний хөндийн мэс засалд 3 үйлчлүүлэгч, хөнгөвчлөх эмчилгээнд 6, үйлчлүүлэгч тус бүр 3 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ.

УНТЭ, УХТЭ-ийн 1-р сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



**Хоёр. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн оношлогооны кабинетийн хүлээгдэл:**

2017 оны 1 дүгээр сард УНТЭ, УХТЭ, УГТЭ, СЭМҮТ-ийн оношлогооны тасгуудад хүлээгдэл бүртгэгдсэн байна.


УНТЭ-ийн бүдүүн гэдэсний дурангийн шинжилгээ хийлгэхээр 31 үйлчлүүлэгч 7-14 хоног, рентген 14 үйлчлүүлэгч 1-14 хоног, хэвлийн эхо 98, MRI 5, захын судасны эхо хийлгэхээр 11 үйлчлүүлэгч 3-6 хоног, тархины цахилгаан бичлэг хийлгэхээр 5 үйлчлүүлэгч 2-6 хоног хүлээж үйлчлүүлжээ.

УХТЭ-т рентген зураг авахуулахаар 60, хэвлийн эхо 90, зүрхний цахилгаан бичлэг хийлгэхээр 23, дурангийн шинжилгээнд 38 үйлчлүүлэгч тус бүр 1-15 ба түүнээс дээш хоног, нүдний уг харах 9, MRI/КТГ хийлгэхээр 1 үйлчлүүлэгч 7-14 хоног, холтер хийлгэхээр 1 үйлчлүүлэгч 2 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.


УГТЭ-т хэвлийн эход харуулахаар 65, рентген зураг авахуулахаар 22, доплерграфийн шинжилгээнд 7, зүрхний цахилгаан бичлэг хийлгэхээр 23, тархины цахилгаан бичлэг хийлгэх 4, зүрхний эход харуулахаар 5 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ.

СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээ хийлгэхээр 170 үйлчлүүлэгч бүртгэгдсэний 85 өдөртөө, 28 үйлчлүүлэгч 1 хоног, 15 үйлчлүүлэгч 2 хоног, 35 үйлчлүүлэгч 3-6 хоног, 8 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

Төв эмнэлгүүдийн оношлогооны кабинетийн 1-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээний 11, 12, 1-р сарын хүлээгдэл /үйлчлүүлэгчийн тоогоор/




**Гурав. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн лабораторийн шинжилгээний хүлээгдэл:**

2018 оны 1 дүгээр сард УХТЭ, УГТЭ лабораторийн шинжилгээний хүлээгдлийг бүртгэн мэдээлсэн.

УХТЭ-т бактериологийн шинжилгээ 16, цусны шинжилгээ өгөхөөр 57, биохими 62, иммунологи шинжилгээнд 6, коагулограмм 10 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

УГТЭ-т биохимийн шинжилгээ өгөхөөр 62, коагулограмм өгөхөөр 10, цусны шинжилгээ 57, бактериологийн шинжилгээнд 16 үйлчлүүлэгч үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

УХТЭ, УГТЭ-ийн лабораторийн кабинетийн 1-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



**Дөрөв. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:**

2018 оны 1 дүгээр сард хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, УАУТХ бүртгэн мэдээлсэн. ГССҮТ-ийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээнд 1-р сард хүлээгдэл бүртгэгдээгүй байна.

УНТЭ-ийн зүрх судасны тасагт 1, дотоод шүүрлийн тасагт 2 үйлчлүүлэгч тус бүр 1-3 хоног хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн.

УХТЭ-т 1-р сард 208 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр 1-14 хүртэл хоногийн хугацаанд хүлээсэн байна. Үүнд: Бөөр судлалын тасагт 11 үйлчлүүлэгч 7-30 хоног, зүрх судасны тасаг 12, мэс засал 89, хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт 69 үйлчлүүлэгч тус бүр 1-14 хоног, мэдрэлийн тасагт 22 үйлчлүүлэгч 3-6 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.


УГТЭ-т 1-р сард нийт 120 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнээс: мэдрэлийн мэс засалд 37 үйлчлүүлэгч 1-30 хоног, зүрх судасны тасагт 20, бөөр судлалын тасагт 10, мэдрэлийн тасаг 12, нүдний тасагт 13 үйлчлүүлэгч тус бүр 1-14 хүртэл хоног, мэс засалд 5, уушгины тасагт 5, чих хамар хоолойн тасагт 9, хоол боловсруулах эрхтэн судлалын тасаг 9 үйлчлүүлэгч 1-6 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ.

ЭХЭМҮТ-ийн эрсдэлтэй жирэмсэн судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 5 үйлчлүүлэгч 1-6 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн.


УАУТХ-ийн уламжлалт эмчилгээний тасагт 1-р сард 52 үйлчлүүлэгч 1-30 хүртэл хоногоор хүлээж үйлчлүүлжээ. Үүнээс 14 үйлчлүүлэгч 1-3 хоног, 11 үйлчлүүлэгч 3-6 хоног, 18 үйлчлүүлэгч 7-14 хоног, 9 үйлчлүүлэгч 15-30 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

СЭМҮТ-ийн стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 1-3 хоногийн хугацаанд хүлээж байгаа 18, 3-6 хоног 47, 7-14 хоног 65, 15-30 хоногийн хугацаанд 71, нийт 201 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна.

Сүүлийн 6 сарын хугацаанд СЭМҮТ-ийн неврозын тасагт хэвтэн эмчлэхээр бүртгэгдсэн үйлчлүүлэгчийн хүлээгдэл /тоогоор/



Сүүлийн 6 сарын хугацаанд УАУТХ-ийн уламжлалт эмчилгээний тасагт хэвтэн эмчлэхээр бүртгэгдсэн үйлчлүүлэгчийн хүлээгдэл /тоогоор/



**Тав. НЭМГ-ын харъяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:**


НЭМГ-ын харъяа 8 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн олон хоногийн хүлээгдэл Сонгинохайрхан, Налайх дүүргийн ЭМТ-ийн мэдрэл, ХУД-ийн ЭМТ-ийн дотор, БЗД-ийн НЭ-ийн доторын тасаг, Наркологийн төв тус бүр 15-30 хоногийн хүлээгдэлтэй үйлчилсэн байна.

Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2018 оны 1-р сарын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг хүснэгтээр харуулав.


№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	СХД ЭМТ	ХУД ЭМТ	НД ЭМТ	ЧД ЭМТ	БГД ЭМТ	БЗД НЭ	БН ЭМТ	Наркологийн төв	
1	Мэдрэл	Ор хүлээж байгаа өвчтний тоо	45	15	18		30		20		
		1-3 хоног	10		5		6				
		3-6 хоног	12	15	3		12		11		
		7-14хоног	18		8		12		9		
		15-30 хоног	5		2						
		1 сараас дээш									
2	Дотор	Ор хүлээж байгаа өвчтний тоо	98	74	61	12	53	78	9		
		1-3 хоног	17	15	23	8		22			
		3-6 хоног	17	23	25	4	3	28	9		
		7-14хоног	64	29	13		50	15			
		15-30 хоног		7				13			
		1 сараас дээш									
3	Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа өвчтний тоо	31	0			16				
		1-3 хоног	5				8				
		3-6 хоног	12				8				
		7-14хоног	14								
		15-30 хоног									
		1 сараас дээш									
4	Наркологийн тусламж үйлчилгээ	Ор хүлээж байгаа өвчтний тоо								82	
		1-3 хоног								25	
		3-6 хоног									32
		7-14хоног									19
		15-30 хоног									6

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 1 дүгээр сард 28630 дуудлага бүртгэгдсэний 32,3%-ийг 0-20 минутад, 30,3%-ийг 21-40 минутад, 18,7%-ийг 41-60 минутад, 18,7%-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 11, 12, 1-р сард ирсэн дуудлагын тоо /хүрч үйлчилсэн хугацаагаар/



Нийслэлийн түргэн тусламжийн төвд сүүлийн 6 сарын хугацаанд ирсэн нийт дуудлагын тоо:



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ЧАНАР, МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН АЛБА